

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

307.	Тахарын албаны тухай	1334
308.	Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1352
309.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1352
310.	Монгол Улсын Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1353
311.	Монгол Улсын Хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1354
312.	Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай	1354
313.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1355
314.	Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай	1356
315.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1356
316.	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1357

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

317.	Зохицуулалт хийх тухай	Дугаар 174	1357
------	------------------------	------------	------



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАХАРЫН АЛБАНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, хуяглан харгалзах, оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах чиг үүрэг бүхий Монгол Улсын Тахарын алба /цаашид “Тахарын алба” гэх/-ны тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндэс, Тахарын албаны алба хаагчийн эрх зүйн байдлыг тогтооход оршино.

2 дугаар зүйл.Тахарын албаны тухай хууль тогтоомж

2.1.Тахарын албаны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“шүүхийн аюулгүй байдал” гэж шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, шүүх хуралдааны журам сахиулах, шүүхийн харуул хамгаалалт, барилга байгууламж, түүний орчны аюулгүй байдлыг;

3.1.2.“хамгаалалтын арга хэмжээ” гэж шүүх, шүүгчийн аюулгүй байдал, гэрч, хохирогч, тэдгээртэй хамаарал бүхий этгээдийг хамгаалахын тулд Тахарын албанаас авч хэрэгжүүлж байгаа аюулгүй байдлын арга хэмжээг;

¹Монгол Улсын Үндсэн хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.



3.1.3."шүүгч, гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээд" гэж тэдгээрийн нөхөр /эхнэр/, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн болон дагавар, үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охиныг.

4 дүгээр зүйл.Тахарын албаны үйл ажиллагааны үндсэн зарчим

4.1.Тахарын алба нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан зарчмаас гадна дараах зарчмыг баримтална:

- 4.1.1.шуурхай байх;
- 4.1.2.энэрэнгүй байх;
- 4.1.3.нууцлалыг хамгаалах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТАХАРЫН АЛБА, ТҮҮНИЙ ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРЭГ

5 дугаар зүйл.Тахарын алба

5.1.Тахарын алба нь шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, шүүхийн тодорхой төрлийн шийдвэр болон энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий хууль сахиулах бие даасан байгууллага мөн.

5.2.Тахарын алба туг болон бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний загвар, хэрэглэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.3.Тахарын алба тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

5.4.Тахарын алба улсын төсвөөс санхүүжих бөгөөд төсөв нь түүний хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан байна.

6 дугаар зүйл.Тахарын албаны чиг үүрэг, бүтэц

6.1.Тахарын алба нь нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх ба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 6.1.1.шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах;
- 6.1.2.гэрч, хохирогчийг хамгаалах;
- 6.1.3.яллагдагч, ялтныг хуяглан хүргэх;



- 6.1.4.яллагдагч, гэрчийг албадан ирүүлэх;
- 6.1.5.ялтан шилжүүлэх;
- 6.1.6.оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах;
- 6.1.7.хуульд заасан бусад чиг үүрэг.

6.2.Тахарын алба шаардлагатай тохиолдолд шүүн таслах ажиллагааны явцад хөрөнгө битүүмжлэх, шүүхэд ирсэн нотлох баримтыг хадгалах, хамгаалах, хуулиар шүүх хуралдаанд зайлшгүй оролцуулахаар заасан зохигч, хэргийн оролцогчийг албадан авчрах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

6.3.Тахарын алба нь Тахарын албаны төв байгууллага болон тойргийн журмаар зохион байгуулагдсан Тахарын албад /цаашид “тойргийн тахарын алба” гэх/-аас бүрдэнэ.

6.4.Тахарын албаны орон тооны дээд хязгаар, зохион байгуулалтын бүтцийг Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд² заасны дагуу тогтооно.

6.5.Тахарын албаны төв байгууллага нь шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, захиргааны удирдлага, санхүү, хангалт үйлчилгээ хариуцах, дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий үндсэн бүтэцтэй байна.

6.6.Энэ хуулийн 6.5-д заасан дотоод хяналт-аюулгүй байдлын нэгжийг бусад чиг үүрэг хариуцсан нэгжээс бие даалган байгуулна. Дотоод хяналт-аюулгүй байдлын алба хаагчийг тус нэгжийн даргад мэдэгдэхгүйгээр томилох, өөрчлөх, чөлөөлөхийг хориглоно.

6.7.Тахарын албаны шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх үндсэн бүтэц нь дараах чиг үүрэг бүхий нэгжтэй байна:

- 6.7.1.шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах;
- 6.7.2.гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах;
- 6.7.3.мөрдөн шалгах, эрэн сурвалжлах;
- 6.7.4.яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

6.7.5.бусад нэгж.

6.8.Тойргийн тахарын албаны зохион байгуулалтын бүтцийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

²Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2004 оны 16 дугаарт нийтлэгдсэн.



6.9.Тойргийн тахарын албаны үйл ажиллагааг тойргийн тахар өдөр тутмын шуурхай удирдлагаар хангаж ажиллана.

6.10.Тахарын алба дэргэдээ сургалтын түшиц газар, өөрийн үйл ажиллагааны чиглэлээр шинжилгээ, судалгаа явуулах үүрэг бүхий нэгжтэй байж болно.

7 дугаар зүйл.Тахарын албаны төв байгууллагын чиг үүрэг

7.1.Тахарын албаны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.1.1.Тахарын албаны үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

7.1.2.Тахарын албаны үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах;

7.1.3.Тахарын албаны алба хаагчийг зэвсэг техник, нэг бүрийн тусгай хэрэгсэл, хувцас, бусад хэрэгслээр хангах;

7.1.4.алба хаагчийг сургах, давтан сургах, тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах;

7.1.5.Тахарын албаны алба хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

7.1.6.дотоод, гадаадын байгууллагатай харилцах, хамтран ажиллах;

7.1.7.хуульд заасан бусад чиг үүрэг.

8 дугаар зүйл.Тэргүүн тахарын бүрэн эрх

8.1.Тахарын албыг тэргүүн тахар удирдах бөгөөд Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.Тахарын албаны үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, удирдах;

8.1.2.Тахарын албаны үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг энэ хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн батлах, мөрдүүлэх;



8.1.3.Тахарын албаны чиг үүрэгтэй холбогдсон асуудлаар хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд мэдээлэл өгөх, санал тавих;

8.1.4.Тахарын албаны үйл ажиллагааны талаар гарсан гомдлыг шийдвэрлэх;

8.1.5.Тахарын албыг төлөөлж дотоод, гадаадын байгууллагатай харилцах, хамтран ажиллах;

8.1.6.хуульд заасан бусад бүрэн эрх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ШҮҮХ, ШҮҮГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

9 дүгээр зүйл.Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ

9.1.Тахарын алба нь шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

9.1.1.шүүхийн харуул хамгаалалтыг хэрэгжүүлэх, шүүх хуралдааны журам сахиулах;

9.1.2.шүүхийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, өөрчлөх, засварлахад аюулгүй байдлын зөвлөмж гаргах;

9.1.3.шүүгчид аюулгүй байдлын хамгаалалтын талаар сургалт явуулах;

9.1.4.шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах;

9.1.5.яллагдагчийг хуяглан хүргэх;

9.1.6.шүүхийн дуудснаар ирэхгүй байгаа яллагдагч, гэрчийг албадан ирүүлэх;

9.1.7.оргон зайлсан яллагдагчийг эрэн сурвалжлах, баривчлах.

9.2.Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангахдаа хамгаалалтын дараах арга хэмжээг авна:



- 9.2.1.урьдчилан сануулах;
- байгуулах;
- 9.2.2.биечилсэн болон техникийн хамгаалалт зохион
- 9.2.3.бусад хамгаалалт.

9.3.Шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулж шүүгч, түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэнд, шүүгчийн эд хөрөнгөд хохирол учирсан, эсхүл учирч болзошгүй бодит нөхцөл байдал үүсвэл шүүгч өөрийгөө болон өөрийн хамаарал бүхий этгээд, эд хөрөнгөө хамгаалалтад авахуулах тухай хүсэлтээ тойргийн тахарын албанд гаргана.

9.4.Тойргийн тахар хүсэлтийг хүлээн авч нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 9.2-т заасан хамгаалалтын арга хэмжээг нэн даруй зохион байгуулна.

9.5.Шүүгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний хугацааг тойргийн тахар тогтоох бөгөөд уг хугацааг сунгах шаардлагатай гэж үзвэл тэргүүн тахард танилцуулж шийдвэрлэнэ.

9.6.Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хамтран батална.

9.7.Тахарын алба шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шаардлагатай гэж үзвэл улсын яллагчийг хамгаалалтад авч болно.

10 дугаар зүйл.Урьдчилан сануулах

10.1.Шүүх, шүүгчийн аюулгүй байдалд заналхийлж, хор аюул учруулж болзошгүй нь тогтоогдсон этгээдэд хүлээлгэх ял шийтгэлийн талаар Тахарын албаны алба хаагч бичгээр урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна.

11 дүгээр зүйл.Биечилсэн болон техникийн хамгаалалт

11.1.Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Тахарын албанаас тодорхой хугацаагаар биечлэн, эсхүл тусгай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглан хяналт тавьж хамгаална.

11.2.Шүүх, шүүгчийн аюулгүй байдалд хохирол учирсан, эсхүл учирч болзошгүй бодит нөхцөл байдал тогтоогдвол биечилсэн болон техникийн хамгаалалтын арга хэмжээг нэн даруй авна.



11.3.Хувийн хамгаалалтын тухай хуулийн³ 12.1-д заасан нэг бүрийн тусгай хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангаж, шаардлагатай гэж үзвэл шүүгчийн биед болон гэрт тусгай техник хэрэгсэл суурилуулж болно.

12 дугаар зүйл.Бусад хамгаалалтын арга хэмжээ

12.1.Шаардлагатай тохиолдолд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалтын бусад арга хэмжээг хэрэглэнэ.

13 дугаар зүйл.Шүүх хуралдааны журам сахиулах, аюулгүй байдлыг хангах

13.1.Тахарын алба шүүхийн аюулгүй байдлыг хангах зорилгоор шүүх хуралдааны танхимд эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлж, шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

13.2.Шүүх хуралдааны журам сахиулах, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Тахарын албанаас шүүхийн хуягийг томилно.

13.3.Тахарын албанаас шүүх хуралдааны хэвийн үйл ажиллагааг хангах явцад аюултай, гэнэтийн нөхцөл байдал үүсвэл шүүх хуралдааныг түр хугацаагаар завсарлуулахаар шүүх хуралдаан даргалагчид үндэслэл бүхий санал тавьж шийдвэрлүүлнэ.

13.4.Тахарын алба нь шүүх хуралдааны явцад үүсч болох эрсдэлтэй нөхцөл байдалд дүгнэлт хийж цаашид хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид үндэслэл бүхий санал хүргүүлж болно.

13.5.Шүүх хуралдааны журам сахиулах нарийвчилсан журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хамтран батална.

14 дүгээр зүйл.Шүүхийн хуяг, түүний эрх хэмжээ

14.1.Тэргүүн тахар нь тухайн тойргийн шүүхэд ажиллах хуягийн тоог холбогдох шүүхийн тамгын газрын даргатай зөвшилцөн тогтоож, Тахарын албаны алба хаагчийг шүүхийн хуягаар томилно.

14.2.Шүүхийн хуяг тойргийн тахарын албаны бүрэлдэхүүнд багтах

³Хувийн хамгаалалтын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2001 оны 25 дугаарт нийтлэгдсэн.



бөгөөд түүнийг Тахарын алба мэргэжлийн удирдлагаар хангана.

14.3.Шүүхийн хуяг шүүхийн дотоод журамд захирагдан ажиллах бөгөөд түүний үйл ажиллагаанд шүүхийн тамгын газрын дарга ерөнхий хяналт тавина.

14.4.Шүүхийн тамгын газрын дарга нь шүүхийн хуягийн үйл ажиллагаатай холбогдсон санал, хүсэлтээ харьяалах Тахарын албаны удирдлагад танилцуулна.

14.5.Шүүх хуралдааны журам сахиулах хуяг нь энэ хуульд заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

14.5.1.цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан яллагдагчийг шүүх хуралдаанд хүргэж ирсэн хуяглан хүргэгчээс хүлээн авах;

14.5.2.яллагдагчийг хяналтдаа байлган шүүх хуралдаанд хуяглан харгалзах;

14.5.3.шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах;

14.5.4.шүүх хуралдааны дэг зөрчсөн яллагдагч, зохигч, оролцогчийг шүүгчийн захирамжийн дагуу хуралдааны танхимаас гаргах, дуудсан үед оруулах;

14.5.5.танхимд байгаа бусад хүн шүүх хуралдааны журам зөрчсөн бол шүүх хуралдаан даргалагчийн шийдвэрээр танхимаас гаргах;

14.5.6.шүүх хуралдааны явцад болон завсарлах хугацаанд цагдан хоригдсон яллагдагчийг өмгөөлөгчөөс бусад хүнтэй уулзуулахгүй байх, бусдаас эд зүйл авах, дамжуулахгүй байх арга хэмжээг авах;

14.5.7.хорих ялаар шийтгэгдсэн ялтныг хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр хяналтдаа байлган гэр бүлийнхэнтэй нь уулзуулах;

14.5.8.ялтныг хуяглан хүргэгчид хүлээлгэн өгөх.

14.6.Шүүхийн харуул хуяг нь шүүхийн байрыг хамгаалж, журмын дагуу үзлэг шалгалт хийн шүүхийн байранд нэвтрүүлэх, шүүхийн байрны гадна орчны аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

14.7.Тахарын алба нь батлан хамгаалах болон хууль сахиулах



байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан иргэнийг тав хүртэл жилийн хугацаагаар гэрээгээр ажиллуулж, шүүхийн харуул хуягийн үүргийг гүйцэтгүүлж болох ба тухайн иргэнд уг албан тушаалын цалингийн тавин хувиар тооцож хөлс олгоно.

14.8.Шүүх хуралдааны явцад эсэргүүцэл үзүүлэх, эмх замбараагүй байдал үүсч болзошгүй нөхцөл байдал үүсвэл Тахарын алба болон цагдаагийн байгууллагаас нэмэлт хүч татан ирүүлэх ажлыг тухайн тойргийн тахар зохион байгуулна.

14.9.Тахарын алба шүүхийн хуягт галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгслийг албан хэрэгцээнд олгож, ашиглалтад хяналт тавина. Шүүхийн харуул хуягийг гэрээгээр гүйцэтгэж байгаа ажилтанд галт зэвсэг олгохгүй.

14.10.Шүүх бүрэлдэхүүн, хуралдаанд оролцогчийн амь нас, эрүүл мэндэд хүч хэрэглэн халдсан, эсхүл шүүх хуралдааныг хэвийн явуулах боломжгүй болсон тохиолдолд шүүхийн хуяг биеийн хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл, галт зэвсгийг хууль тогтоомжид заасан журмын дагуу хэрэглэнэ.

14.11.Шүүхийн хуяг нь шүүх хуралдааны үед хуралдаан даргалагчид захирагдана.

15 дугаар зүйл.Яллагдагч, гэрчийг албадан ирүүлэх ажиллагаа

15.1.Тахарын алба нь яллагдагч, гэрчийг шүүгчийн захирамжийн дагуу шүүхэд албадан ирүүлнэ.

15.2.Шүүхэд албадан ирүүлэх ажиллагааны зардлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

16 дугаар зүйл.Гэрч, хохирогчийг хамгаалах

16.1.Тахарын алба нь гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх ажлыг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

16.2.Тахарын алба хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалалтад авах ажиллагааг зохион байгуулна.

16.3.Тахарын албаны хамгаалалтад гэмт хэрэгтэй тэмцэх бусад байгууллага өөрийн мөрдөн шалгаж байгаа гэмт хэргийн гэрч, хохирогчийг шилжүүлэн өгч болно.

17 дугаар зүйл.Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах



17.1.Тахарын алба дараах тохиолдолд мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулна:

17.1.1.шүүх, шүүгчийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх;

17.1.2.оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах;

17.1.3.гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бүхий этгээдийг хамгаалах аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ЯЛЛАГДАГЧ, ЯЛТНЫГ ХУЯГЛАН ХҮРГЭХ, ОРГОН
ЗАЙЛСАН ЯЛЛАГДАГЧ, ЯЛТНЫГ ЭРЭН СУРВАЛЖЛАХ

18 дугаар зүйл.Яллагдагч, ялтныг хуяглан хүргэх,
хуяглан харгалзах

18.1.Тахарын алба нь шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хуяглан хүргэх ажиллагааг дараах тохиолдолд зохион байгуулна:

18.1.1.яллагдагчийг цагдан хорих байрнаас шүүх хуралдаанд, шүүх хуралдаанаас цагдан хорих байранд хүргэх;

18.1.2.шүүхийн шийдвэрээр хорих ялаар шийтгүүлсэн ялтныг хорих ангид, шүүх хуралдаанд оролцох ялтныг хорих ангиас шүүх хуралдаанд, шүүх хуралдаанаас хорих ангид хүргэх;

18.1.3.цагдан хорих байрыг нүүлгэн шилжүүлэх.

18.2.Шаардлагатай гэж үзвэл яллагдагч, ялтныг хуяглан хүргэх хугацаанд үзэгдэх орчинг хязгаарлаж болно.

18.3.Хуяглан хүргэх ажиллагааг тусгай тоноглон автомашинаар шаардлагатай үед галт тэрэг, нисэх онгоцоор тээвэрлэн хүргэнэ.

18.4.Яллагдагч, ялтныг галт тэрэг, нисэх онгоцоор хуяглан хүргэхдээ хүлээн авах Тахарын алба, цагдаагийн байгууллагын удирдлагад урьдчилан мэдэгдэнэ.

18.5.Цагдан хоригдож байгаа яллагдагч нь эрүүл мэндийн



шалтгаанаар цагдан хорих байраас гадуур эмчлүүлэх шаардлагатай болсон бол Тахарын алба хуяглан харгалзана.

19 дүгээр зүйл.Хуяглан хүргэх харуул, түүний гүйцэтгэх үүрэг

19.1.Энэ хуулийн 18.1-д заасан яллагдагч, ялтныг хуяглан хүргэх үүргийг Тахарын албаны хуяглан хүргэх харуул гүйцэтгэнэ.

19.2.Хуяглан хүргэх ажиллагааг ердийн журмаар болон хүч нэмэгдүүлэн гүйцэтгэнэ.

19.3.Нийтэд аюул учруулах магадлал багатай яллагдагч, ялтныг ердийн журмаар хуяглан хүргэнэ.

19.4.Шаардлагатай гэж үзвэл яллагдагч, ялтныг хүч нэмэгдүүлэн хуяглан хүргэнэ. Хүч нэмэгдүүлэн хуяглан хүргэх ажиллагааны журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хамтран батална.

19.5.Тахарын алба хуяглан хүргэх болон хуяглан харгалзах алба хаагчид галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгслийг албан хэрэгцээнд олгож, ашиглалтад хяналт тавина.

19.6.Яллагдагч, ялтан оргох, оргохоор завдах, эсхүл Тахарын албаны алба хаагчид халдсан үед алба хаагч биеийн хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл, галт зэвсгийг хууль тогтоомжид заасан журмын дагуу хэрэглэнэ.

19.7.Хуяглан хүргэх ажиллагаанд албаны нохой ашиглаж болно.

20 дугаар зүйл.Хуяглан хүргэх болон хуяглан харгалзахад хориглох зүйл

20.1.Хуяглан хүргэх болон хуяглан харгалзахад дараах зүйлийг хориглоно:

20.1.1.галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл, харуулын үүргийг бусдад шилжүүлэх;

20.1.2.зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд галт зэвсгийг сумлах;

20.1.3.зориулалтын бус тээврийн хэрэгсэл ашиглах;

20.1.4.хуяглан хүргэж байгаа тусгай зориулалтын



тээврийн хэрэгсэлд гадны хүн, ачаа тээвэрлэх;

20.1.5.техникийн аюулгүй байдал хангагдаагүй тээврийн хэрэгсэл ашиглах;

20.1.6.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүргэх чиглэл, байршлыг өөрчлөх;

20.1.7.хуяглан хүргэх болон хуяглан харгалзаж байгаа этгээдийг хяналтгүй орхих, гадны хүнтэй уулзуулах;

20.1.8.зурвас, захиа, холбооны хэрэгсэл, эд зүйлс дамжуулж өгөх, авах;

20.1.9.хуяглан хүргэх ажиллагааны нууцлалыг задруулах;

20.1.10.хуульд заасан бусад зүйл.

21 дүгээр зүйл.Ялтан шилжүүлэх

21.1.Тахарын алба нь ялтныг гадаад улсад шилжүүлэх, гадаад улсаас шилжүүлэн авах ажиллагааг гүйцэтгэнэ.

21.2.Ялтан шилжүүлэхэд нисэх онгоц, галт тэрэг, тусгай тоногдсон автомашин ашиглана.

22 дугаар зүйл.Цагдан хорих байр, хорих ангийг нүүлгэн шилжүүлэх ажиллагааны үед яллагдагч, ялтныг хуяглан хүргэх

22.1.Цагдан хорих байрыг нүүлгэн шилжүүлэхэд Тахарын алба яллагдагчийг хуяглан хүргэх ажиллагааг зохион байгуулна.

22.2.Хорих ангийг өөрчлөн байгуулах, татан буулгах болон байгалийн гамшиг учирсан үед нүүлгэн шилжүүлэхэд Тахарын алба хорих байгууллагын хүсэлтээр ялтныг хуяглан хүргэх ажиллагаанд дэмжлэг үзүүлж болно.

22.3.Хуяглан хүргэх, нүүлгэн шилжүүлэх ажиллагааны журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.



23 дугаар зүйл.Оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах

23.1.Тахарын алба шүүгч, улсын яллагч, гэрч, хохирогчийг хамгаалах зорилгоор оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах ажиллагааг хариуцан гүйцэтгэнэ.

23.2.Эрэн сурвалжлах ажиллагаа зохион байгуулах үед нийслэл, аймаг, сум, дүүргийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, хотын захирагч, цагдаа, хорих, батлан хамгаалах, хил хамгаалах алба зэрэг байгууллагаас хүн хүч, зэвсэг, автомашин, шатахуун, техник хэрэгсэл, түр байрлах байр шаардан гаргуулах, дайчлан ашиглаж болно.

23.3.Тахарын албаны алба хаагч нь эрэн сурвалжлах ажиллагааны үед боомт, хилийн зурвас, гааль, төрийн тусгай хамгаалалтын бүсэд нэвтрэн ажиллах эрхтэй.

23.4.Ялтан оргон зайлсан тохиолдолд тухайн хорих байгууллага Тахарын албанд нэн даруй мэдэгдэж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх үүрэгтэй.

24 дүгээр зүйл.Хорих байгууллагад онцгой нөхцөл байдал үүссэн үед хамтран ажиллах

24.1.Хорих байгууллагад бусдыг барьцаалах, өмч хөрөнгө эвдэж сүйтгэх, галдан шатаах зэрэг нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн нөхцөлд Тахарын алба хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах зорилгоор хорих байгууллагатай хамтран ажиллана.

ТАВДУГААР БҮЛЭГ ТАХАРЫН АЛБАНЫ АЛБА ХААГЧ, АЖИЛТАН, ТЭДГЭЭРИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

25 дугаар зүйл.Тахарын албаны албан тушаалын төрөл, ангилал, цол

25.1.Тахарын алба нь төв байгууллагын дарга, шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх чиг үүрэг хариуцсан тэргүүн дэд дарга, захиргааны удирдлага, санхүү, хангалт, үйлчилгээ хариуцсан дэд даргатай байна.

25.2.Дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах чиг үүрэг хариуцсан нэгжийн дарга нь Тахарын албаны дэд дарга байна.



25.3.Тахарын албаны төв байгууллагын дарга нь тэргүүн тахар, тэргүүн дэд дарга нь тэргүүн шадар тахар, дэд дарга нь шадар тахар, тойргийн тахарын албаны дарга нь тойргийн тахар, тойргийн тахарын албаны дэд дарга нь тойргийн шадар тахар, нэгжийн дарга нь тахар цолтой байна.

25.4.Энэ хуулийн 25.3-т зааснаас бусад алба хаагч нь туслах тахар цолтой байна.

25.5.Тэргүүн тахар, тэргүүн шадар тахар, шадар тахар цолыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, тойргийн тахар, тойргийн шадар тахар, тахар, туслах тахар цолыг тэргүүн тахар тус тус олгоно.

26 дугаар зүйл.Тахарын албаны тангараг

26.1.Тахарын албаны алба хаагч “Монгол Улсын иргэн би Монгол Улсын Тахарын албанд алба хаахдаа хуулийг дээдлэн биелүүлж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, хуулиар хүлээсэн үүргээ үнэнчээр биелүүлж ажиллахаа батлан тангараглая. Тангарагаа зөрчвөл хуулийн хариуцлага хүлээнэ.” гэж тангараг өргөнө.

26.2.Тахарын албаны алба хаагчийн тангараг өргөх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

27 дугаар зүйл.Тэргүүн тахар, тэргүүн шадар тахар, шадар тахар,тойргийн тахар, тойргийн шадар тахар, тахар, тэдгээрийг томилох, чөлөөлөх

27.1.Монгол Улсын тэргүүн тахарыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.

27.2.Тэргүүн шадар тахар, шадар тахарыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, тойргийн тахар, тойргийн шадар тахар, тахарыг тэргүүн тахар тус тус томилж, чөлөөлнө.

27.3.Тэргүүн тахар, тэргүүн шадар тахар, шадар тахар, тойргийн тахар, тойргийн шадар тахар, тахард нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан байна:

27.3.1.Тэргүүн тахард нэр дэвшигч нь таваас доошгүй жил хуульчаар, эсхүл хууль сахиулагчаар ажилласан, удирдах ажлын дадлага туршлагатай, сүүлийн таван жил улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй;



27.3.2.Тэргүүн шадар тахар, шадар тахар, тойргийн тахард нэр дэвшигч нь хууль сахиулагчаар арваас доошгүй жил ажилласан, улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй;

27.3.3.Тойргийн шадар тахар, тахард нэр дэвшигч нь хууль сахиулагчаар таваас доошгүй жил ажилласан.

27.4.Тойргийн тахар, тойргийн шадар тахар, тахар нь албан үүргээ гүйцэтгэх хугацаандаа тухайн тойрогтоо амьдрах бөгөөд томилогдсон тойрогт гэр бүлээрээ амьдрах нөхцөлийг Тахарын алба хангана.

28 дугаар зүйл.Тахарын албаны алба хаагч, ажилтан

28.1.Тахарын албанд батлан хамгаалах болон хууль сахиулах байгууллагад алба хаагчаар гурваас доошгүй жил ажилласан, ял шийтгүүлж байгаагүй, 35 хүртэлх насны Монгол Улсын иргэнийг эрүүл мэнд, бие бялдар, мэргэжил, боловсролын болон ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг харгалзан томилно.

28.2.Энэ хуулийн 28.1-д заасан алба хаагчийг тэргүүн тахар томилж, чөлөөлнө.

28.3.Тахарын алба нь тухайн албаны үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах чиг үүрэг бүхий захиргааны ажилтантай байна.

28.4.Тахарын албаны захиргааны ажилтан нь Төрийн албаны тухай хуульд⁴ заасан төрийн захиргааны албан хаагчид тавигдах болзол, шаардлагыг хангасан байна.

29 дүгээр зүйл.Тахарын албаны алба хаагчийн дүрэмт хувцас

29.1.Тахарын албаны алба хаагч дүрэмт хувцас, хувийн дугаар бүхий таних тэмдэгтэй байна.

29.2.Тахарын албаны алба хаагчийн дүрэмт хувцас, таних тэмдгийн загвар, хэрэглэх журам болон энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан цол олгох журмыг Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар тогтооно.

30 дугаар зүйл.Тахарын албаны алба хаагчийн эрх, үүрэг, баталгаа, хориглох зүйл

30.1.Тахарын албаны алба хаагчийн эрх, үүрэг, баталгаа

⁴Төрийн албаны тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.



болон хориглох зүйлийг Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна.

31 дүгээр зүйл. Тахарын албаны алба хаагчид олгох нөхөн олговор, тэтгэмж

31.1. Тахарын албаны алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд тухайн алба хаагчийн гэр бүлийн нэг гишүүнд түүний үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг 10 жилийн туршид сар тутам олгоно.

31.2. Энэ хуулийн 31.1-д заасан тэтгэмжийг авах эрх бүхий гэр бүлийн гишүүний дарааллыг дараах байдлаар тогтооно:

31.2.1. тухайн алба хаагчтай гэрлэлтээ бүртгүүлсэн эхнэр /нөхөр/;

31.2.2. насанд хүрээгүй хүүхэд;

31.2.3. тухайн алба хаагчтай хамт амьдарч, асрамжид байсан эцэг, эх, насанд хүрээгүй дүү;

31.2.4. тухайн алба хаагчийн асрамжид байсан төрсөн ах, эгч, дүү нь хөгжлийн бэрхшээлтэй бол.

31.3. Энэ хуулийн 31.2-т заасан эрх бусдад шилжихгүй.

31.4. Тахарын албанаас чөлөөлөгдсөн иргэнийг урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан эрүүл мэнд, амь насанд нь хохирол учруулсан бол энэ хуулийн 31.1-д заасан баталгаа нэгэн адил хамаарна.

31.5. Энэ хуулийн 31.1-д заасан зардлыг Засгийн газар хариуцан гаргаж, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

32 дугаар зүйл. Тахарын албаны галт зэвсэг

32.1. Тахарын албаны алба хаагч биедээ галт зэвсэг авч явах эрхтэй.

32.2. Галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх үндэслэл, журмыг холбогдох хуулиар зохицуулна.



**ЗУРГААДУГААР БҮЛЭГ
ТАХАРЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ
ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА, БУСАД ЗҮЙЛ**

**33 дугаар зүйл.Тахарын албаны үйл ажиллагаанд
тавих хяналт**

33.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Тахарын албаны үйл ажиллагаанд Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд⁵ заасны дагуу хяналт тавина.

33.2.Шүүх, прокурорын байгууллага нь Тахарын албаны хууль сахиулах үйл ажиллагаанд холбогдох хуульд заасан үндэслэл журмын дагуу хяналт тавина.

33.3.Тахарын албаны мөрдөн шалгах нууц ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороо хяналт тавина.

33.4.Тахарын албаны төв байгууллага нь тойргийн тахарын албаны үйл ажиллагаанд дотоод хяналт тавьж, хууль тогтоомж, хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлж, илэрсэн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авна.

**34 дүгээр зүйл.Тахарын албаны үйл ажиллагаанд
гомдол гаргах**

34.1.Тахарын албаны үйл ажиллагааны талаарх гомдлыг тухайн байгууллагын удирдлага, эсхүл дээд шатны байгууллагад гаргана.

34.2.Гомдлыг хүлээж авсан байгууллага, албан тушаалтан тав хоногийн дотор шалгаж, хариу өгнө.

34.3.Энэ хуулийн 34.2-т заасан байгууллага, албан тушаалтны шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

35 дугаар зүйл.Тахарын албаны алба хаагчийн ёс зүйн дүрэм

35.1.Тахарын албаны алба хаагч нь Тахарын албаны алба хаагчийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллана.

⁵Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2004 оны 16 дугаарт нийтлэгдсэн.



35.2.Тахарын албаны алба хаагчийн ёс зүйн дүрмийг Тахарын албаны төв байгууллагын дарга батална.

35.3.Тахарын албаны алба хаагчийн сахилга, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааг Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна.

36 дугаар зүйл.Мэдээллийн сан

36.1.Тахарын алба нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд туслах тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан, сүлжээ байгуулж ашиглана.

36.2.Тахарын албаны мэдээллийн сан нь төрийн нууцад хамаарна.

37 дугаар зүйл.Тахарын албаны тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

37.1.Тахарын албаны тухай хууль тогтоомж, өргөсөн тангаргаа зөрчсөн алба хаагчид ял шийтгэл хүлээлгэхээргүй бол энэ хууль болон Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Тахарын албаны алба хаагчийн ёс зүйн дүрмийг баримтлан сахилгын хариуцлага ногдуулна.

37.2.Тахарын алба, алба хаагчийн энэ хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан, хүч хэрэглэн эсэргүүцсэн, албан үүрэгтэй нь холбогдуулан алба хаагч, түүний хамаарал бүхий этгээдийг болон тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн үндэслэлээр албанаас чөлөөлөгдсөн иргэнийг заналхийлсэн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

37.3.Энэ хуулийн 37.2-т заасан “хамаарал бүхий этгээд” гэдгийг энэ хуулийн 3.1.3-т заасны дагуу ойлгоно.

38 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

38.1.Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 9.1.7 дахь заалт:

“9.1.7. тахарын алба оргосон яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, шүүх, шүүгч, гэрч, хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх.”

2/11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсэг:

“11.8. Тахарын алба оргосон яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, баривчлах, шүүх, шүүгч, гэрч хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдалд халдлага, хор аюул учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй.”

2 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Тагнуулын байгууллага цагдаа”, 9 дүгээр зүйлийн 9.2.5 дахь заалтын “цэрэг, цагдаа” гэсний дараа “тахарын” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Тахарын албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.1.5 дахь заалт нэмсүгэй:



“8.1.5.хорих ангид онцгой нөхцөл байдал үүссэн үед аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээнд хамрагдаж байгаа гэрч, хохирогчийн талаар тахарын албанд мэдээлэх.”

2 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.3 дахь хэсгийн “тохиолдолд” гэсний дараа “тахарын албатай хамтран” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.2 дахь хэсгийн “цагдаагийн, хэрэв уг этгээд баривчлах, хорих ял эдэлж байгаа бол ял эдлүүлж байсан баривчлах байр, хорих анги нь тус тус” гэснийг “тахарын алба” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “сэжигтэн, яллагдагчийг баривчлах,” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Тахарын албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“30.2.Шүүх хуралдааны журам сахиулах, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, яллагдагчийг хуяглан хүргэх, шүүхийн дуудснаар ирэхгүй байгаа яллагдагч, гэрч, зохигч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх, шүүхээс оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах үүргийг тахарын алба гүйцэтгэнэ.”



2 дугаар зүйл.Энэ хуулийг Тахарын албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Монгол Улсын хилийн тухай хуулийн 32 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6, 7 дахь заалт нэмсүгэй:

“6/шүүн таслах ажиллагаа болон хорих анги, цагдан хорих байрнаас оргон зайлж улсын хил нэвтрэхийг завдсан, эсхүл нэвтрэсэн яллагдагч, ялтны талаарх мэдээлэл, лавлагааг тахарын албанд гаргаж өгөх, хамтран ажиллах;

7/хилийн бүс орчимд эрэн сурвалжлагдаж байгаа яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, баривчлах ажиллагаанд оролцох, хүн хүч, автомашин, техник хэрэгслээр туслах.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Тахарын албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 8 дахь заалт нэмсүгэй:



“8/уул, ой модонд бүгсэн оргодол яллагдагч, ялтныг эрэн сурвалжилж байгаа тахарын албанд газар орны онцлог, байгалийн тогтоц, байршлын талаар мэдээлэл өгөх, газарчлах, хамтран ажиллах.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Тахарын албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 30.1.15 дахь заалт нэмсүгэй:

“30.1.15.шаардлагатай тохиолдолд тухайн орон нутагт хуульд заасан үүргээ хэрэгжүүлж байгаа тахарын албанд шаардагдах хүн хүч, автомашин, техник, шатахуун, орон байр болон бусад хэрэгслээр туслах;”

2 дугаар зүйл.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.15 дахь заалтын дугаарыг “30.1.16” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Тахарын албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 9, 10 дахь заалт нэмсүгэй:

“9/шаардлагатай тохиолдолд хуульд заасны дагуу гэмт хэргийн гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахад туслах зорилгоор харьяа анги салбарынхаа бүсэд байршуулж аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах;”

10/шаардлагатай тохиолдолд улсын хэмжээнд эрэн сурвалжилж буй оргодол яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, баривчлах, хорих ангийг нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд хүн хүч, техник хэрэгслийн дэмжлэг тусалцаа үзүүлэх.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Тахарын албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5 дахь хэсгийн “цагдаагийн байгууллагад” гэснийг “тахарын албанд” гэж, 77 дугаар зүйлийн 77.10 дахь хэсгийн “цагдаагийн байгууллага” гэснийг “тахарын алба” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Тахарын албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.6 дахь хэсгийн “цагдаагийн байгууллагад” гэснийг “тахарын албанд” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Тахарын албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 5 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 174

Улаанбаатар
хот

Зохицуулалт хийх тухай

Төсвийн тухай хуулийн 10.1.14-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн зохицуулсан жагсаалт”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Жагсаалтад заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн ажлын хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайханд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

САНГИЙН САЙД

Ч.УЛААН

Засгийн газрын 2013 оны 174 дүгээр
ТОГТООЛЫН ХАВСРАЛТ

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2013 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ
САНХҮҮЖИЛТЭД ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ САНАЛ (сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр хүч, чадал, байршил	Эхлэх хугацаа	Төсөвт өргөг			2013 онд санхүүжж			Тайлбар
			Батлагдсан	Шинэчлэгдсэн	Батлагдсан	Хасах	Нэмж	Зохихуу- лардсан	
A	Б	1	3	4	5	6	7	8-5-8+7	10
XXI	БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	-	30,760.8	-	16,060.0	7,960.8	7,960.8	16,060.0	-
XXI.1.5	Ханх Залтэр болтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Гунгуусуудыг Шилжүүлэн, Боршоо хилийн болтуудын хэсэгчлэн хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулах	2012	2,000.0	-	1,710.0	1,181.1	-	528.9	Боршоогийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад 166.8 сая, Газар нурьдалд 180.6 сая, Шилжүүлэгдэ 181.5 сая төгрөг, нийтдээ 528.9 сая төгрөгийг хуулиар батлагдсан аяныг хэрэгжүүлэхэд санхүүжүүлнэ. Урьдх мөнгө ашиглагдахгүй.
XXI.1.19	Аймаг, орон нутгийн орон сууцны ижтгэрийн шугам сурьца (21 аймаг, сумдад)	2011	12,000.0	-	3,000.0	-	6,550.0	9,550.0	2011 онд 450.0 сая, 2012 онд 2,000.0 сая төгрөгийн санхүүжилт үйлдсэн, үүдэлд нь 2013 онд санхүүжилдэж дуусна.
XXI.1.49	Сайшандаг аж үйлдвэрийн цогцлолбор болон Балануурын үйлдвэргэлт- технологийн парын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах	2013	1,000.0	-	1,000.0	980.0	-	20.0	2013 оны төсвийн тухай хуулиар хавсралтын Үйлдвэр, хөвөө аж ахуйн саймын багцын ХХУИШ.4.7-д тусгагдсан төсөл, арга хэмжээний даяардан туслагдсан тул, хасах шаардлагагүй.
XXI.1.51	21 аймгийн төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах	2013	3,570.8	-	2,160.0	-	1,410.8	3,570.8	Чойбалсангийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад 133.2 сая, Улиастайд 132.1 сая, Өндөржаанд 99.3 сая, Даланзадгад 745.5 сая, Зүүнмодод 592.2 сая, Хөвдэд 1,285.8 сая, Чойрт 582.8 сая төгрөг, нийтдээ 3,570.9 сая төгрөгийн санхүүжилт хийнэ.



XXI.1.52	2 аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх (Баян-Өлгий, Сэлэнгэ)	2013	2013	1,590.0	-	1,590.0	669.1	920.9	Баян-Өлгий аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловруулахад 920.9 сая төгрөг зарцуула. Харин Сэлэнгийн Суьбаатарын ерөнхий төлөвлөгөө орон нутгийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлэн боловруулсан тул түүнд төсөвлөгдсөн 669.1 сая төгрөгийг хасах шаардлагатай.
XXI.1.54	Замын-Үүд, Алтанбулаг хилийн боомтын ерөнхий төлөвлөгөөг боловруулах	2013	2013	600.0	-	600.0	260.7	339.3	Замын-Үүд боомтын ерөнхий төлөвлөгөө боловруулахад 208.3 сая, Алтанбулагийн боомтын ерөнхий төлөвлөгөө боловруулахад 131.0 сая төгрөг, нийтдээ 339.3 сая төгрөгийн санхүүжилт хийгдэнэ. Үлдэгдэл хөрөнгө ашиглагдахгүй.
XXI.1.60	Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөний тодотголын дагуу бусчлэл, инженер-геологи, газар хөдөлгөөн мугжлалын нарийвчилсан зураг төсөл боловруулах	2013	2014	2,500.0	1,000.0	1,000.0	750.0	250.0	Уг ажлаас Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөний тодотголын дагуу бусчлэлийн төлөвлөгөөний ажл хийгдэх бөгөөд энэхүү ажлын өртөг нь 1,000.0 сая төгрөг ба инженер-геологийн судалгаа, газар хөдөлгөөн мугжлалын болон газар дээрх болон доорх зураглал хийж, мэдээллийн сан үүсгэх ажилтай давхардсан тул төсөвт өртгөөс 1.5 тэрбум төгрөг хасах саналтай.



XXI.1.66	Гаарын тос боловруулах үйлдвэрийн гол дэд бугац (Дархан-Уул)	2013	2014	3,000.0	-	3,000.0	2,619.9	-	380.1	Энэ төсөл нь техникийн зураг төсөлгүй, 2013 онд ажил хийгдэхгүй тул төлөвлөгөөнөөс хасгах шаардлагатай. Зураг төслийн хөрөнгийг Эдийн засгийн хөгжлийн сайдын багц дахь зураг төслийн хөрөнгийн жагсаалтад тусгуулаад байгаа. Баримтын ажлыг 2014 онд гүйцэтгэх тул хэрэжүүлэх хуацааг 2014 он болгох.
XXI.1.74	XXI эрүүн хөрөнгийн гадна цавар, бөхир ус, дулаан, хоолбор, ислэйвэний шугам сүлжээний барилга угсралтын ажил (Завхан, Уластай)	2013	2014	4,500.0	-	2,000.0	1,500.0	-	500.0	Энэхүү төсөл эрэг хэмжээний зураг төсөл нь хийгдэж эгсгэртгээр хөндөгдсөн боловч зураг төсөлд дахин засвар орох боломж дүр хуудлаар авах амжилтаар илхон байгуулаж хугацаатай үйлдүүлж 2013 оны санхүүжилтийг 2014 он руу шилжүүлэх саналтай.

Хаяг:
 “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци,
 Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
 И-мэйл: turin_medeelel@parliament.mn
 Утас: 262420
 Хэвлэлийн хуудас: 1.75
 Илгээх: 14003